

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 12 дугаар сарын 10-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-25

1.Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.11.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/	4-18
2.Эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, эрчим хүчний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлого, арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, хариуцлагын талаарх Эрчим хүчний сайдын мэдээллийг сонсох	18-25

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
12 дугаар сарын 10-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 41 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Тулга, С.Эрдэнэболд;

Чөлөөтэй: Н.Номтойбаяр, Г.Очирбат, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Д.Ганбат, Л.Гантөмөр, С.Лүндэг;

Тасалсан: О.Амгаланбаатар, Н.Батсүмбэрэл, Э.Болормаа.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр хэлэлцэх асуудлын дарааллын 3 дугаарт орсон Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг 1 дүгээрт хэлэлцэх горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 4

Бүгд: 15

73.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг.Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.11.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Эдийн засгийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Урьболд, Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын зөвлөх Б.Лхамсүрэн, Э.Нямбаяр, шинжээч Б.Ариунтуяа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын дэд захирал Д.Бат-Өлзий, Хууль зүй, дотоод хэргийн яамны Олон улсын арбитрын хэлтсийн дарга О.Цолмон, Сангийн яамны Татварын бодлогын газрын зөвлөх Ч.Мөнхшүр, Гаалийн ерөнхий газрын дэд дарга Г.Энхтайван, Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгч Б.Лхагважав, мөн танхимын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Саруул, Гадаад худалдааны бичиг баримт баталгаажуулалтын газрын дарга Э.Бадамхорол нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, зөвлөх М.Отгон нар байлцав.

Хуулийн төслийн талаар Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан, Ч.Анар, Х.Жангабыл, Г.Хосбаяр, А.Ариунзаяа, Р.Эрдэнэбүрэн нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү нар хариулж, тайлбар хийв.

Г.Тэмүүлэн: Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг батлахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	5
Бүгд:	17

70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлахтай холбогдуулан хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоол гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	8
Бүгд:	17

52.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, эрчим хүчний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлого, арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, хариуцлагын талаарх Эрчим хүчний сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, мөн яамны Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын

дарга Д.Батзориг, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Стратеги, төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Энхтүвшин, Эрчим хүчний зохицуулах хорооны Үнэ тарифын газрын дарга Б.Эрдэнэбулган нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, зөвлөх М.Отгон нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар 15 цаг 37 минутаас хуралдааныг даргалав.

Эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, эрчим хүчний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлого, арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, хариуцлагын талаарх мэдээллийг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр, Х.Жангабыл нарын тавьсан асуултад Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, эрчим хүчний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлого, арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, хариуцлагын талаарх Эрчим хүчний сайдын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 15 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 19 минут үргэлжилж, ирвэл зохих 29 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 62.1 хувийн ирцтэйгээр 16 цаг 00 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 12 дугаар сарын 10-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
14 цаг 41 минут.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Байнгын хорооны гишүүдийн ирц хүрсэн байна. Ирцийг та бүхэнд танилцуулъя. Чинбаатарын Анар гишүүн, Энхтайваны Бат-Амгалан гишүүн, Дуламын Бум-Очир гишүүн, Хажекберийн Жангабыл гишүүн, Батбаярын Жаргалан гишүүн, Загджавын Мэндсайхан гишүүн, Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн, Ганбатын Хосбаяр гишүүн, Дамдины Цогтбаатар гишүүн, Өлзийхүүгийн Шижир гишүүн, Баттөмөрийн Энхбаяр гишүүн, Жадамбын Энхбаяр гишүүн, Лутаагийн Энхнасан нарын гишүүд хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн байна. Ингээд 12 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх 3 асуудал байгаа. Даргын зөвлөл дээрээс тавьсан дараалал дээр жоохон өөрчлөлт оруулах шаардлага байгаа. 1 дүгээрт, Эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, эрчим хүчний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлого, төсөв, төлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээллийг сонсохоор байгаа 1 дүгээрт. 2 дугаарт, Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан байгаа. 3 дугаарт, Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл, энэ соёрхон батлах асуудал байгаа. Ийм 3 асуудал байна. 3 асуудалтай холбоотойгоор саналтай гишүүд байна уу? Энхбаяр гишүүн, Анар гишүүн. Ж.Энхбаяр сайд, Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Ж.Энхбаяр: Энэ Евразийн эдийн засгийн холбоотой хийх гэрээг 1 дүгээр асуудал болгож өгөөч.

Г.Тэмүүлэн: Тэгье, горимын саналаар санал хураалтыг явуулна. Анар гишүүн, адилхан санал, ойлголоо. Хоёрдугаарх асуудал нь хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан гээд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Бямбацогт сайд танилцуулах байгаа. Бямбацогт сайд байхгүй байгаа юм байна. Тэгэхээр 2 дугаар асуудал танилцуулах сайд нь байхгүй учраас энэ асуудлыг дахиад хойшлуулъя. Сайд заавал ч үгүй Байнгын хороонд танилцуулах үүрэгтэй байгаа.

3-д бичигдсэн байгаа Монгол Улс болоод Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээг соёрхон батлах тухай хуулийн төслийг нэг дэх асуудал болгон хэлэлцье гэдэг асуудлаар горимын санал гарсан. Горимын саналыг дэмжье гэдэг асуудлаар санал хураалтыг явуулъя. Бэлдье, санал хураалтдаа бэлтгээрэй, хуруугаа уншуулаарай. Эхний горимын санал дээр санал хураалт явуулна. Бэлэн байгаа 11, болж байна. Санал хураалтыг

явуулъя. Ж.Энхбаяр гишүүний горимын саналыг дэмжье гэдгээр санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Санал хураалт 73,3 хувиар дэмжигдлээ. Ингээд хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Нэг.Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.11.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

1 дүгээр асуудал, Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье. Хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Эдийн засаг, хөгжлийн сайд бөгөөд Тэргүүн Шадар сайд Жадамбын Энхбаяр сайд танилцуулна. Таныг микрофонд урьж байна.

Ж.Энхбаяр: Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, та бүгдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Монгол Улс 2024 онд нийт 162 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт эргэлт 27,4 тэрбум долларт хүрсэн байна. Үүнээс экспорт 15,8 тэрбум ам.доллар, импорт 11,6 тэрбум ам.доллар болж, худалдааны тэнцэл 4,2 тэрбум ам.долларын ашигтай гарсан байна. 2024 оны байдлаар Оросын холбооны улстай хийсэн худалдаа 2,7 тэрбум ам.долларын алдагдалтай байна. Сүүлийн 10 жилд ОХУ экспортлох хэмжээ төдийлөн нэмэгдээгүй бөгөөд шатахууны эрэлт нэмэгдсэнтэй холбоотойгоор импорт өсөж, худалдааны бүтэц бүхэлдээ тэнцвэргүй болсон. ОХУ нь Евразийн эдийн засгийн холбооны гишүүн тул холбооны бусад гишүүн орнуудтай адил нэгдсэн гаалийн тарифын бодлого хэрэгжүүлдэг. Монгол Улсаас Евразийн эдийн засгийн холбоонд экспортлох бараанд 15-аас 50 хувийн гаалийн татвар ногдуулж, эрүүл ахуй, хорио цээрийн өндөр шаардлага тавьж байгаа нь экспортын боломжийг хязгаарлаж байгаа юм.

Мөн нийт экспортын 91,2 хувь нь, уул уурхайн бүтээгдэхүүний 94,7 хувь нь, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний 82,7 хувийг зөвхөн БНХАУ-д экспортолж байна. Энэ нь нэг улсын зах зээлээс хэт хамааралтай болж, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд туссан эдийн засгийн аюулгүй байдалд бүрэлдэхүүн хэсэгт, аюулгүй байдалд сөрөг нөлөө учруулах хэмжээнд хүрээд байна. ОХУ нь ЕАЭЗХ-ны гишүүн орон тул тус холбооны дүрэмд заасны дагуу холбооны 5 гишүүн орон нь нэгдсэн татварын тогтолцоотой, бусад гадаад улс орнуудтай хийх худалдаанд нэгдсэн нэг цонхны бодлого хэрэгжүүлдэг бөгөөд импортоор орж ирэх бүтээгдэхүүнүүдэд 15-аас 50 хувийн татвар ногдуулахаас гадна, эрүүл ахуйн хорио цээр, техникийн зохицуулалтын өндөр шалгуур, шаардлага тавьдаг тул Монгол Улсаас экспорт хийх бололцоо хумигдмал байна.

Иймээс гол түнш орнуудтай хийх худалдаанд тулгарч буй тарифын болон тарифын бус саад тотгорыг бууруулж, харьцангуй давуу талтай бүтээгдэхүүнээ саадгүй экспортлох, дотоодын үйлдвэрлэлд шаардлагатай орц, түүхий эд, тоног төхөөрөмжийг хямд өртгөөр импортлох нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна. Үүнийг хэрэгжүүлэх гол хэрэгсэл нь чөлөөт худалдааны хэлэлцээрүүдийг байгуулах явдал юм.

Тус хэлэлцээр нийт 31 зүйл, 4 хавсралтаас бүрдэх бөгөөд хөрөнгө оруулалт, үйлчилгээний, худалдаа, банк санхүү, төлбөр тооцоо зэрэг асуудлыг тусгаагүй. Зөвхөн 367 барааны хүрээнд тохиролцсон болно. Мөн хэлэлцээр 3 жилийн хугацаатай бөгөөд талууд өөрөөр тохиролцоогүй бол хугацааг сунгасанд тооцно. Хэлэлцээрийн хүрээнд 2 талаас ижил тооны буюу бараа тодорхойлох кодчиллын уялдуулсан систем БТКУС-н 6 оронтой кодоор 367 нэр төрлийн бараанд тарифыг шууд тэглэх, тариф бууруулах, тохирсон квотын хэмжээнд тарифыг тэглэх, тохирсон квотын хэмжээнд тарифын хөнгөлөлт эдлэх гэсэн үндсэн 4 төрлөөр тарифын саад тотгорыг бууруулахаар тохиролцсон.

Түүнчлэн улаан буудай, өндөг зэрэг манай улсын стратегийн болон хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний импортын нөлөөллийг бага байлгахад онцгойлон анхаарсан бөгөөд тоо хэмжээний хязгаарлалтыг тогтоох, зарим барааг хасуулах замаар дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах зохицуулалтыг хэлэлцээрийн төсөлд тусгасан болно.

Олон улсад чөлөөт худалдааны хэлэлцээр хийхэд түгээмэл ашигладаг ерөнхий тэнцвэрийн загварын тооцооллоор хэлэлцээр хэрэгжсэнээр манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 0,2 хувь, хөрөнгө оруулалт 2,57 хувь, Еврази эдийн засгийн холбоо руу хийх экспорт 24,1 хувь өсөх боломжтой байна. Тухайлбал, мах, махан бүтээгдэхүүн, ноос, ноолуур, нэхмэл, сүлжмэл болон арьс шир зэрэг боловсруулах үйлдвэрийн гол бүтээгдэхүүний экспорт 42-оос 152 хувиар нэмэгдэж, Монголын бүтээгдэхүүн гаалийн татваргүйгээр өргөн зах зээлд нэвтрэх нөхцөл бүрдэнэ. Мөн Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнуудын хоорондын худалдааны түр хэлэлцээр байгуулах асуудал нь Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тус тус тусгагдсан болно.

Цагаан алт, Хүнсний хувьсгал, Шинэ хоршоо хөдөлгөөн зэрэг төрийн бодлогын хүрээнд хөдөө аж ахуйн салбарыг дэмжих ажил идэвхтэй өрнөж буй энэ цаг үед тус хэлэлцээр нь дотоодын боловсруулах үйлдвэрлэл болон нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлж, малчин өрх болон үйлдвэрлэгч, экспортлогчдын орлогыг өсгөх, ажлын байрыг нэмэгдүүлэх ач холбогдолтой. Мөн дээр дурдсан Монгол Улсын бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан бүс нутгийн интеграцид нэгдэх, нэг эдийн засгаас хараат байдлыг бууруулах, экспортын зах зээлийг тэлэх, төрөлжүүлэх зорилтыг хэрэгжүүлэх, худалдааг хөнгөвчлөх, хувийн хэвшил, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих ач холбогдолтой.

Экспортын үйл ажиллагаа хөнгөвчлөх чиглэлээр чухал ахиц гарч, зардал буурах боломж бүрдэх бөгөөд орц материалыг экспортын барааны өртгийн 50 хувьд тооцсон тарифын хөнгөлөлт эдлэх, барааг 4 цагийн дотор олгох, гарал үүслийн гэрчилгээг нөхөн гаргах боломжтой болох, эрсдэлийн үнэлгээнд тулгуурласан гаалийн шалгалтын шинэ зохицуулалт хэрэгжих, 5 мянган еврогоос бага үнийн дүнтэй бараанд гарал үүслийн гэрчилгээ шаардахгүй байх зэрэг өөрчлөлт нь бизнесийн орчныг сайжруулах юм. Энэхүү хэлэлцээр нь Олон улсын гэрээний тухай хуулийн дагуу заавал соёрхон батлах олон улсын гэрээ тул асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Энхбаяр сайдад баярлалаа. Уг хуулийн төсөлтэй холбогдуулаад өнөөдрийн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг

танилцуулъя. Энхбаяр сайд Эдийн засаг, хөгжлийн сайд бөгөөд Монгол Улсын Тэргүүн шадар сайд, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД, Төмөр-Уяагийн Жамбалцэрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны ТНБД, Бат-Ирээдүйн Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Мэндбаярын Дондогдорж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын газрын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Хөдөө аж ахуйн яамныхан байхгүй байна уу, дуудаарай, байна уу, ойлголоо. Цэндгомбын Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Даваасүрэнгийн Довчинсүрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Бат-Өлзий Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын дэд захирал, Гэлэгжамцын Энхтайван Гаалийн ерөнхий газрын дэд дарга, Баяраагийн Урьболд Эдийн засаг, хөгжлийн яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын Эдийн засгийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга, Одгэрэлийн Цолмон ХЗДХЯ-ны Олон улсын гэрээ, хамтын ажиллагааны газрын Олон улсын арбитрын хэлтсийн дарга, Баасангийн Лхамсүрэн Эдийн засаг, хөгжлийн яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын зөвлөх, Энхтайваны Нямбаяр Эдийн засаг, хөгжлийн яамны Худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын зөвлөх, Мөнхшүр Сангийн яамны Татварын бодлогын газрын зөвлөх, Баярсайханы Ариунтуяа Эдийн засаг, хөгжлийн яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын шинжээч, Лхагважав Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгч, Саруул Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Ерөнхий нарийн бичгийн дарга, Эрдэнэчулууны Бадамхорол Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Гадаад худалдааны бичиг баримт, баталгаажуулалтын газрын дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр оролцож байгаа юм байна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор асуулт асуух гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя. Хосбаяр гишүүнээр тасалъя. Анар, Энхнасан гишүүн асуулт асууна.

Л.Энхнасан: Баярлалаа. Гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах энэ асуудал 2 дахь удаагаа орж ирж байна. Тэгээд тодруулах нэг асуудал байна. Энэ өмнөх хуралдаанаас ч гэсэн ярьж байсан энэ нөгөө тамхины гаалийн татвар тэг байгаа. Тэгэхлээр энэ асуудлыг өмнө хурал дээр ч гэсэн ярьж байсан. Одоо тэрнээс хойш яам энэ дээр ямар нэгэн ажил хийсэн үү?

Яагаад энийг ярьж байна гэвэл би өөрөө Тамхины хууль чуулганаар ороод хэлэлцэхээр байгаа, ажлын хэсэгт орсон байгаа. Тэгээд хэрвээ гаалийн татвар тэг байвал энэ нөгөө бусад орнуудаас орж ирж байгаа нөгөө тамхины энэ юу нь тэгш бус болох тийм магадлалтай. Яагаад гэвэл Казахстан, Оросоос тамхи нэлээн их орж ирдэг гээд ийм асуулт байна.

Г.Тэмүүлэн: Энхнасан гишүүний асуултад хариулъя. Шадар сайд Ж.Энхбаяр.

Ж.Энхбаяр: Тамхитай холбоотой асуудал гарсан. Хэрвээ энэ Евроазийн холбоо Монгол Улс хоорондын энэ худалдааны гэрээ соёрхон баталсан нөхцөлд

дагаж Их Хурлын тогтоол гарахаар бэлдэж байгаа. Тэр тогтоолын 2 заалттай нэг нь энэ Тамхины хуультай холбоотой зохицуулалтын асуудлыг хаврын чуулганд багтаж гэрээ хэрэгжихээс өмнө шийдвэрлэх. Энд бид тамхины, тамхинд ноогддог онцгой татварын зохицуулалтыг энэ гэрээний ямар нэгэн хүлээсэн үүрэгт ороогүй. Бид онцгой татвараараа тэр тарифын зохицуулалтыг хийгээд, худалдааны тэнцвэртэй, тэгш байдлыг хангах бололцоотой. Энэ бол гэрээнээс гадуур манай бүрэн эрхийн хэмжээндээ бидэнд байгаа гэсэн үг. Тэгэхээр гарах тогтоолын төслийн 1 дүгээр санал энэ байгаа.

2 дугаар санал нь энэ гэрээ 3 жил болоод ямар нэгэн санал гараагүй бол автоматаар сунгагдах учиртай. Энэ дээр манай Их Хурлын гишүүн Ариунзаяа гишүүний гаргасан саналын дагуу бид ярилцаад, энийгээ хэмжих дүн шинжилгээ хийгээд 3 жилийн хугацаа дуусахаас өмнө энэ Их Хуралдаа танилцуулаад явах ийм үүргийг Засгийн газар авч байгаа гэсэн ийм 2 хувилбартай тогтоолын төслийг санаачлаад, Байнгын хорооны дарга танилцуулах байх, тэр хүрээгээрээ зохицуулчихна гэж. Ямар ч гэсэн энэ гэрээ хүчин төгөлдөр болохоос өмнө тамхины асуудал шийдэгдсэн, тэгш бус худалдааны байдал үүсгэхгүй байхыг бид энэ хаврын чуулгандаа багтаж эцэслэж чадна гэж бодож байна.

Г.Тэмүүлэн: Энхнасан гишүүн нэмж тодруулъя.

Л.Энхнасан: Тэгэхлээр нөгөө гаалийн асуудал нь тэгээрээ байгаад, онцгой татвараараа зохицуулна гэсэн үг үү? Хэрвээ онцгой татвараар зохицуулна гээд тэгвэл бусад өөр орноос орж ирж байгаа, магадгүй нөгөө Солонгосоос, Японоос, Хятадаас гээд орж ирдэг юм байна лээ шүү дээ. Тэр давхар татвартай болоод ганцхан Орос, Казахстанас орж ирж байгаа нь ийм тэгш бус ийм байдал үүсэхгүй юү?

Г.Тэмүүлэн: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Евразийн эдийн засгийн холбооны гишүүн 5 орноос Монголын зах зээлд импортолсон тамхины онцгой албан татварыг бусад орнуудаас импортолж байгаа тамхины татвартай дүйцүүлэн худалдааны тэгш байдлыг, өрсөлдөөний тэгш байдлаар хангаж хийнэ, яг тэгж болно, тийм. Тэгэхээрээ тэдний онцгой татвар арай өндөр гарна л гэсэн үг. Тэндээс импортолж байгаа гарал үүсэл нь онцгой татвар өндөртэй, бусад орнуудынх арай бага. Яагаад гэвэл бусад орнууд бид гаалийн татвар байгаа болохоор. Ингээд дотооддоо тэгш байдлаа хангах гэдэг дээр сая энэ 2 талын хэлэлцээрийн явцад бид нэлээн олон төрлийн бараан дээр дотоодын зах зээлээ хамгаалсан, худалдаа нь тэгш байдлыг, шударга өрсөлдөөнийг хангасан ийм зохицуулалтуудыг хийж чадсан.

Мөн энэнтэй адилхан квотын зохицуулалтууд. Жишээлбэл өндөг дээр гэхэд Монгол Улсад хэрэглээ 500 сая ширхэг өндөгний хэрэглээ байгаа. Бид импортоор дийлэнхээ хангаж байсан бол энэ Хүнсний хувьсгал бодлогын үр дүнд нийт хэрэглээнийхээ 90 хувийг дотоодоосоо бүрэн хангаж.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Нэмж хариулъя Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Өндөгнийхөө 90 хувийг дотоодоосоо хангаж чадсан, 400 гаруй сая ширхгийг нийлүүлж чадаж байгаа. Бид хэлэлцээрийн явцад бид 90 сая ширхэг өндгийг ОХУ-аар бид квотын хөнгөлөлт өгч авна гэсэн үг. Тэгэхээр дотоодынхоо зах

зээл хамгаална. Импорт нь тодорхой тоог нь тохирсон. Улаан буудайн дээр гэхэд мөн адил квот буюу бид 50 мянган тонн улаан буудайг импорт нь квоттой, бусдыг нь нөгөө татварын тарифын бодлогоор хамгаална, хаана гэсэн маягаар. Ингээд шар айраг дээр татварын жоохон буулт хийгээд ер нь 2 талд зохицсон, цагаан архи дээр зохицуулж чадсан. Ингээд нэг маргаан үүсгээд байсан гол, гол хамгаалах ёстой түүхий эдээ бид хамгаалаад, бараагаа хамгаалж чадсан гэж үзэж байгаа.

Г.Тэмүүлэн: Энхнасан гишүүн нэмж тодруулъя.

Л.Энхнасан: Ер нь яах вэ энэ хэлэлцээрийн ач холбогдлыг нь ойлгож байгаа. Яагаад гэвэл үндэсний аюулгүй байдлаа бодоод энэ ач холбогдолтой гэдгийг ойлгож байгаа. Зүгээр энэ Тамхины хууль орж байгаатай холбогдуулаад энэ хууль маань энэ Евразитай цуг орж байгаа болохлоор энэнээс болоод үүдэлтэй асуудал гарах вий гэдэг дээр би эмзэглэж байгаа юм. Тийм болохлоор энэ дээр сайд онцгойлон анхаараад, саяын хийх ажлуудаа хийгээрэй гэж хүсэж байна.

Г.Тэмүүлэн: Энхнасан гишүүнд баярлалаа, санал хэллээ. Анар гишүүн асуулт асууя.

Ч.Анар: Өдрийн мэндийг хүргэе. Бүлгийн хурал дээр асуултаа асуучихсан учраас протоколд саналаа тусгуулъя. Тэгэхээр энэхүү хэлэлцээр нь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, гадаад бодлого, гадаад харилцааны хэм хэмжээгээр бид том зургаараа энэ гэрээ хэлэлцээрийг дэмжихээс өөр аргагүй. Гэхдээ санаа зовж байгаа асуудал нь эдийн засгийн агуулгаараа манай улсын татварын, гаалийн татварын орлого бол төсөвт нэмэр болохгүй байхгүй болох байх гэж санаа зовж байна.

2 дугаарт гадаад худалдааны тэнцлийн баланс нэлээн их хэмжээгээр алдагдах байх. Ж.Энхбаяр сайдын танилцуулга дээр мэдээж дотоодын үйлдвэрлэл дэмжвэл том зах зээл рүү гарах гарц мөн. Гэхдээ дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээнүүд энэ хуулийн төслийн давуу талыг ашиглах хэмжээнд хангалттай бойжоогүй байгаа. Тэгэхээр энэ чиглэлийн үйлдвэрлэл, үйлчилгээнүүд дээр гаднын хөрөнгө оруулалт болон дотоодын үйлдвэрлэлийг дэмжих талаараа дагасан хуулийг хүчин төгөлдөр болохоос наана хуулийн төслүүд болон тогтоол, төсөл, хөтөлбөрүүдийг Эдийн засаг, хөгжлийн яам бэлдэж байгаа гэж хариултаас ойлгосон. Тэрийгээ яаралтай оруулж ирэх хэрэгтэй.

Тэгэхгүй бол энэ танилцуулга дээр байгаа гаднын хөрөнгө оруулалтыг 2,57 хувь дэмжинэ, дотоодын нийт бүтээгдэхүүний 0,02 хувиар нэмэгдүүлнэ гэдэг тоо хангалтгүй. Тэгэхээр энэ эсрэгээрээ бид жижиг, дунд үйлдвэрлэлээ хаах боох, дотоодын зах зээлээ алдах эрсдэл нь илүү өндөр байгаа. Энэ хуулийн төслийн том зах зээл рүү орж ирж байгаа боломжийг нээхийн тулд энэ дээр чиглэсэн хууль тогтоомжийг яаралтай өргөн барих зайлшгүй шаардлагатай шүү. Тэгэхгүй бол бид 3 жилийн дараа энэ гэрээгээ дүгнэх үед Японтой хийсэн хэлэлцээрийн нэгэн адил гадаад худалдааны асар том алдагдал хүлээх эрсдэлтэй байгаа. Энэ дээр онцгойлон анхаарахыг хүсье. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Бараг санал хэлчихлээ дээ, хариулах уу? Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Мэдээж ийм болгоомжлол байгаа. Тийм болохоор бид 3 жилийн түр гэрээ гэж хийж байна. Өнгөрсөн хугацаанд Улсын Их Хурлын шийдвэр гараад, Төрийн тэргүүний санаачилсан Засгийн газрын олон хөтөлбөр хэрэгжлээ. Дотоодын хөнгөн хүнсний үйлдвэрүүдийг бэхжүүлэх ажлууд, технологийн шинэчлэл, тоног төхөөрөмжийн шинэчлэл, олон улсын стандартыг авах, гадаад зах зээлтэй холбоотой гэрээ хэлэлцээрүүд, протокол, техникийн зохицуулалтуудыг хийх гээд өнгөрсөн 2 жилийн хугацаанд энэ Хүнсний хувьсгал, Цагаан алт, Атрын 4 гэсэн аяны хүрээнд чамгүй ажлууд хийлээ.

Одоо дотоодын аж ахуйн нэгжүүд маань энэ 3,5 сая хүнтэй дотоодын зах зээл үндсэндээ ханаж эхэлж байна. Нэгэнт бий болсон энэ чадавх, энэ өнгөрсөн хугацаанд хийгдсэн ажлынхаа үр дүнг бид олон улсын тавцанд сорих цаг болсон гэж үзэж байгаа. Энэ хамгийн таатай буюу манай сэрүүн бүсийн 5 орон Евроазийн орнууд 200 сая хүний зах зээл байгаа. Энэ 200 сая хүний зах зээл манай үйлдвэрлэж байгаа ижил төстэй 10 тэрбум долларын импорт хийж байгаа зах зээл. Тэгэхээр энэ 10 тэрбум долларын эдийн засаг руу бид зах зээл рүү л тэмүүлнэ гэсэн үг буюу энэ сорилтод орно. Ингэж байж манай улс хөгжин дэвшинэ, үйлдвэрлэл эдийн засгийн үр ашиг гарна. Үйлдвэрлэж байж, экспортолж байж л нөгөө хөдөө орон нутаг, ажил амьдрал, малчдын орлогоос авхуулаад олон зүйл ингээд шийдэгдэх болно.

Нөгөө талаас бид Евроазийн эдийн засгаас татварын хөнгөлөлт эдлэх хүсэлтэй 367 барааны жагсаалт байгаа. 222 төрлийн аж үйлдвэрийн бараа байгаа, хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжүүд, хөдөө аж ахуйн сэлбэг хэрэгслүүд, даавуу эдлэлүүд, төмрийн хайлш, ган төмөр эдлэлүүд, л..., турбин, эрчим хүчний янз янзын тоног төхөөрөмжүүд, трансформаторууд, хүнд машин механизмууд гээд манайд өндөр өртөг үүсгэж байгаа, энийгээ бид хямдхан авна гэсэн үг. 94 төрлийн хүнсний бараа байгаа. Энэ голцуу Монгол Улсад тарьдаггүй, ургуулдаггүй, үйлдвэрлэдэггүй нэлээн олон нэр төрлийн бараа орж ирнэ. Ингэснээр иргэдэд сонголт нэмэгдэнэ, бараа хямдарна, хүнсний бараа буюу инфляцыг чиглэсэн бодлого энүүгээр дамжиж хэрэгжих бололцоотой. Эрдэс химийн бүтээгдэхүүний 51 бараа байгаа юм. Нөгөө мал аж ахуйн салбарт хэрэглэж байгаа гол вакцинууд эндээс нийлүүлэгдэж байна. Шингэн антибиотикууд, витаминууд авч байна. Бүх үндсэндээ азотын бордоо буюу хөдөө аж ахуйн салбар болон тэсрэх бодисыг бараг 100 хувь эндээс нийлүүлэлт хийж байна. Авто бензин, дизель түлш, тэгээд л саван, шампунь, угаалгын нутгаас авхуулаад энэ химийн орц бүтээгдэхүүн гээд бидний яг ахуй амьдрал, аж үйлдвэрлэлд хэрэгтэй, өртгийг бууруулахад нөлөөлж байгаа 367 бараа орж ирнэ.

Эсрэг талдаа манай 367 бараа хөдөө аж ахуйн гаралтай бараанууд гарна. 23 төрлийн бараан дээр маргаан үүсгэж бид хэлэлцээр ороод тохироо буюу тохирч зохицуулалтаа хийж, зах зээлээ хамгаалах ажлууд хийсэн. Бид 8 барааг хасуулах санал оруулж, хасуулсан. Дотооддоо үйлдвэрлэж байгаа шингэн сүү, өтгөрүүлсэн сүү, цөцгий, даршилсан ногоо, сонгино, төмс, лууван, манжин энэ тэр гээд нөгөө хүнсний хувьсгалын зорилтод ороод, үр дүн гарч байгаа бараануудаа хасуулсан.

Зарим бараан дээр бид буулт хийсэн. Жишээлбэл өндөг дээр гэхэд 90 сая ширхэг дээр жоохон татварын буулт, түүнээс цааших бол хамгаалалттай гэдэг юм уу. Шар айраг дээр гэхэд одоо манайх 25 хувийн татвартай байгааг бид буулгаад 18,75 болгож жоохон буулт хийсэн буюу дотооддоо боломж хамгаалсан гэсэн үг. Цагаан архи 40 хувийн татварыг бид 30 хувь дээр тохирсон гэсэн үг. Энэ мэтчилнээр нөгөө үйлдвэрлэгч, холбоодтойгоо бид хамтраад ажиллаад хаана хаанаа нэг эвтэйхэн байгаад, хамгаалалтуудаа гол амжилтуудаа хамгаалсан, тэгээд нөгөө

инфляцад чиглэсэн ийм бодлогуудаа хийсэн. 4 төрлийн барааг бол тохиролцож чадаагүй. Энэ бол нөгөө йогурт, амтат жигнэмэг, өрмөцөр, эрдэст ус гэсэн 4 төрлийн татвар дээр.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Жангабыл гишүүн асуулт асууя.

Х.Жангабыл: Та бүхэнд өдрийн мэндийг хүргэе. Монгол Улс болон ЕАЭЗХ, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны хэлэлцээрийг соёрхон батлах тухай төслийг манай улсад ашигтай болохоор 100 хувь дэмжиж байгаа юм.

Надад нэг асуулт байна. Энэ бензин түлшний татварыг тэг болгоно гээд яриад байдаг. Тэгээд энэ эдийн засгийн холбооны тарифын жагсаалт хавсралт 1, 2-оос бензин, дизель түлш гээд нэршлээр нь олохгүй юм. Ингээд судлаад байхаар 97 дахь тоот, 27, 10, 12 гэсэн уялдуулсан кодтой хөнгөн ба хөнгөн бэлдмэл гээд. Энэ тэгээд яг бензин, дизель түлшний татвар нь яг тэг болох юм уу? Одоо бол 80 хүртэл бензин дээр 5 хувь, 80-аас дээш октантай бензинд тэг байгаа л даа. Гэхдээ түлш, түлш дээр бол 5 хувь байгаа. Тэгэхээр энэ 5 хувь хямдарвал буцаагаад энийг онцгой татвараар нөхөж авах онцгой татвар тавих уу? Энэ 26 оны төсөв дээр яаж тусгагдсан бэ? Тэгээд энэ соёрхон баталчихвал энэ хэлэлцээрийн үйлчлэх хугацаа хэзээнээс эхлэх юм бэ? Эдийн засаг, хөгжлийн яамнаас хариулт авъя.

Г.Тэмүүлэн: Жангабыл гишүүний асуултад хариулъя, Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Энэ нэмэгдсэн өртгийн албан татвар болон онцгой албан татварын асуудал нь хамрагдахгүй. Тэгэхээрээ бид энэ онцгой албан татварынхаа өөрчлөлтөөр бодлогынхоо нөгөө авах татвар гол юмнуудаа аваад явна л гэсэн үг. Нэмэлтээр ажлын хэсэг Батхүү дарга хариулах уу, хэн хариулах вэ? Тэр нарийн шатахуунтай холбоотой мэдээллийг.

Г.Тэмүүлэн: Хэдэн номер гэж яах вэ, хойшоо суух ёстой юу? 4 номер. Индрийн микрофон өгчихье.

И.Батхүү: Жангабыл гишүүний асуултад хариулъя. Таны тодруулж асуусан 2 нэр төрлийн бараа жагсаалтад байгаа. Дугаарлалт нь БТКУС кодоороо 271 мянга 012 гэдэг дугаар дээр хөнгөн тос болон бэлдмэл гээд 80, 92, 95 гэсэн бензиний зүйл, 271 019 дээр бусад буюу дизель түлш гээд дизель түлшний асуудал нь орсон байгаа.

Энэ хэлэлцээр маань Монгол Улсын хувьд энэ намрын чуулганаар соёрхон батлагдаад, дотоодын процесс нь дуусна. Нөгөө 5 улсын хувьд өөр өөрийнхөө дотоодын процедурын дагуу соёрхон батлуулах, зөвшөөрөл авах процесс нь зэрэг эхэлчихсэн байгаа. Яг бидэнд ажлын шугамаар авсан мэдээллээр энэ ирэх оны эхний хагас гэхэд бүх улсууд дотоод процессоо дуусгачихна гэж үзэж байгаа. Хэлэлцээр дээр заасан заалтаар бол бүх улсын дотоодын процесс дууссаны дараа харилцан.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Нэмж тодруулъя Жангабыл гишүүн.

Х.Жангабыл: Жишээлэхэд дизель түлш дээр гаалийн татвар 5 хувь байгаа. 5 хувь бол энэ хэлэлцээр хүчинтэй болсноос хойш тэг болох юм байна. Тэгэхээр

дизель түлш 150 төгрөгөөр хямдрах юм байна. Энэ 150 төгрөгийг онцгой татвараар орлуулах байдлаар авах уу, энэ яах юм бэ? Энэ дээр хариулт авъя.

Г.Тэмүүлэн: Индрийн микрофон.

Х.Жангабыл: Өөрөөр хэлбэл 150 төгрөгөөр хямдхан бид борлуулах уу манай импортлогч компаниуд, аль эсвэл онцгой татвар тавих байдлаар татвар нь хэвээрээ үлдэх үү гэсэн асуултад хариулт авъя.

Г.Тэмүүлэн: Батхүү дарга индрийн микрофон.

И.Батхүү: Энэ онцгой албан татвар яг өөрөө бол энэ хэлэлцээрийн хамрах хүрээнд багтахгүй байгаа. Засгийн газраас өөрсдөө бодлогоо гаргаад, тухайн үеийн төсөв, санхүүгийн төсвийн орлого бүрдүүлэлтийн хэрэгцээ шаардлага юу байна, нөгөө талаараа энэ дизель түлш маань өөрөө уул уурхай, хөдөө аж ахуйн гол ашиглагддаг түлш учраас үнийн хөнгөлөлтийн бодлогын онцгой албан татвараараа дэмжээд явах уу гээд бодлогын сонголтоос үр нөлөөг нь судлаад, тухайн үедээ оруулж ирж танилцуулж шийдвэр гаргана.

Г.Тэмүүлэн: Хосбаяр гишүүн асуулт асууя.

Г.Хосбаяр: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Энэ асуудал маань ноднин яг өдийд л нэлээн хүчтэй яригдаж, Эдийн засаг, хөгжлийн сайд Гантөмөр сайдын үед нэлээн хүчтэй яригдаж, бараг л эцсийн шатандаа явж байгаад ингээд зогсонги байдалд орсон. Тэгээд одоо сайжраад асуудлуудаа тухайн үед яригдаж байсан асуудлуудаа тохиролцоод орж ирж байгаа гэж ингэж ойлгож байгаа. Тэгээд тухайн үед Худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга өөр хүн байсан, одоо болохоор Лхагважав дарга эргээд болсон. Тийм учраас ер нь энэ Худалдаа, аж үйлдвэрийн танхим аймаг болгонд салбартай байгаа. Тэгэхээр энэ аймгуудынхаа салбаруудаар дамжуулж ер нь энэ жижиг, дунд бизнес эрхлэгчдийнхээ саналыг сонссон уу, ярилцсан уу? Ер нь олон мэргэжлийн холбоод байгаа хувийн хэвшлийн, эд нарын санал бодлыг солилцсон уу? Ер нь ганц нэг мэргэжлийн холбоод энэ тэндхийн хүмүүс бол эсрэг байр суурьтай хүмүүс байдаг юм байна лээ. Тэгэхээр энэ Худалдаа, аж үйлдвэрийн танхимын шинэ даргын байр суурь энэ юмыг нэг сонсчихмоор байна.

Цаашдаа Худалдаа, аж үйлдвэрийн танхим энэ асуудлаас гадна улсын төсөвтэй холбоотой ч юм уу, ер нь энэ олон яг хувийн хэвшилтэй холбоотой асуудал дээр байр сууриа илэрхийлж, хүчтэй илэрхийлж ингэж бид нартай уулзаж, энэ хурал Байнгын хороон дээр орж ирж байх ийм боломж ер нь байдаг юм уу? Та бүхэнд тийм санал байгаа юу? Тэгэхгүй бол зарим тохиолдолд хувийн хэвшлийнхний санал гээгдээд яваад байна шүү. Ер нь хувийн хэвшлийнхэн бол дор дороо л ажлаа хийж яваа учраас энд төрийнхөн бүх юмыг шийдээд л одоо төр өөрөө эрсдэлээс, бүх эрсдэлээс өөрсдийгөө хамгаалаад л, хувийн хэвшилд бас таатай биш зүйлийг хийгээд байгаа зүйлүүд ажиглагдаад байгаа. Тийм учраас энэ Худалдаа, аж үйлдвэрийн танхимын байр суурийг сонсчихмоор байна.

Г.Тэмүүлэн: Хосбаяр гишүүний асуултад хариулъя, Худалдаа, аж үйлдвэрийн танхим Лхагважав, 6 номер.

Б.Лхагважав: Танхимын Ерөнхийлөгч Лхагважав байна. Гишүүний асуултад хариулъя. Миний бие тухайн үед 14-өөс 19 онд танхимын Ерөнхийлөгч байсан. Түүнээс хойш тэргүүлэгч, Удирдах зөвлөлийн гишүүн нь байнга байж байсан. Энэ Евразийн гэрээний асуудал өнгөрсөн жил 12 сард орж ирэхэд би тэргүүлэгч, Удирдах зөвлөлийн гишүүний хувьд энэ процесст оролцож байсан. Тэгээд тэр үедээ бараг 10 мянган барааны нэр төрөл орж ирээд, тэгээд танхим дээр том эсэргүүцэл болж, тэгээд энэ асуудал хойшлогдсон.

Тэгээд дараа нь хаврын процесст энэ бүх үйл явц танхимтай их холбоотойгоор хэлэлцүүлгүүд явагдаж, тэгээд Гантөмөр даргын ахалж байсан юунд 367 бараан дээр очиход миний бие байнга оролцож явсан. Түүнээс энэ харь гаргаас ирээгүй, энэ бүх процесст явж байсан. Ялангуяа манай дотоодын үйлдвэрлэгчид энэ бий болж байгаа зах зээлээ хамгаалахад, тэд нарыгаа унагачих вий гэсэн асуудлаас болж, тэрийгээ хэд дахин багасгахад бүх процессыг мэдэж байгаа 1 дүгээрт тийм байна.

2 дугаарт би энэ Минск хотод болсон Евразийн гэрээ үзэглэх үед танхимын Ерөнхийлөгчийн ажил түр орлон гүйцэтгэгчийн ажлыг аваад, 2 хоногийн дараа Учрал сайдтай хамт очиж энэ гэрээ зурах үйл явцад оролцож, яг энэ чиглэлээрээ ялангуяа ОХУ-ын Засгийн газрын гишүүдтэй уулзалт хийсэн. Тэгээд ийм асуудал байгаа.

Нөгөө талаасаа энэ гэрээн дээр хамгийн гол асуудал энэ санхүүгийн зохицуулалтын асуудал байгаа л даа нэг дэх нь. Энийг дараа дараагийн нөгөө техникийн ажлууд дээр тодорхой гаргах байх. Нөгөө талаасаа гишүүний тавьж байгаа тэр танхимын оролцоо бол манайх одоо байгаа хуулиараа нийт энэ бизнесийнхээ өмгөөлж, зөвхөн зөвлөгөө өгөх, зөвлөмж өгөх маягаар манай хуультай байгаа.

Хэрэв манай Их Хурлын эрхэм гишүүд маань манай Танхимын хууль маань бараг ойрхон орж ирнэ. Тэгээд энэ Танхимын хуулийг хэрвээ та хэд баталж өгч чадвал бид олон танхимууд яг тухайн, тухайн салбарын танхимууд бий болж, тэрүүгээрээ дуу хоолойгоо нэгтгэсэн төрийн бус байгууллагууд нэгдэж гарах бололцоо бол их гарч ирэх юм шүү. Тийм учраас та хэдээсээ шинэ хуулийг маань баталж өгөөсэй гэж хүсэж байна. Одоо байгаа хуулийнхаа хүрээнд зөвлөмж өгөөд явдаг. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Ариунзаяа гишүүн асуулт асууя.

А.Ариунзаяа: Байнгын хорооны гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Евразийн хэлэлцээрийг дэмжиж байгаа. Энэ дөнгөж одоо яригдаж байгаа асуудал биш, бараг хориод жилийн хугацаанд Монгол Улсын Засгийн газраас ОХУ-д хөрш орны хувьд манайд ээлтэй нөхцөлийг үзүүлээч, манай бизнес эрхлэгчид, манай малчид, тариаланчид, яг хил, хилийн бүсэд амьдарч байгаа хүмүүс ч гэсэн аливаа бараа хөрөнгийг оруулахад маш өндөр татвартай байдаг нь манайхыг бараг маш их хязгаарласан хоригт бараг оруулсан мэт ийм бодлого яваад байна гэдэг хүсэлтийг маш олон жилийн хугацаанд явуулж ирсэн хүсэлтийг тавьж ирсэн.

Тэгээд ер нь энэ гадаад худалдааны тэнцлийг аваад үзэхэд хүртэл Монгол Улсын хувьд 97, 3 хувийн харьцаатай байдаг. 2,9 тэрбум долларын харилцаа үүслээ гэхэд экспортод 100 сая доллар, харин импортоор 2,8 тэрбум долларын ийм

харилцаатай байдаг. Тэгэхээр манай Монгол Улс бол хөрш орноосоо ямар ч ашигтай харилцаа байдаггүй юм, яг хоригт байгаа юм шиг байна гээд энэхүү бүс нутгийн болоод өөрийнхөө энэ татварын бодлогыг авч үзээч гэж хүсэлт гаргасны улмаас яг энэ Евразийн хэлэлцээрт нэгдэж байгаа.

Тэгээд яг одоо энэ хэлэлцээрийн соёрхон батлах үе шат нь яг эцсийн үе шат буюу сая өнгөрсөн 25 оны 4 сард энэ Байнгын хороо, Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийн зөвшөөрлөөр 6 сард Учрал сайд очиж гарын үсэг зурж, 6 улс орны түвшинд хэлэлцээрээ гарын үсэг зурж үзэглэсэн албажуулсан. Одоо энэ 6 улс орны хувьд нэгэн адил соёрхон батлах процесс явж байгаа учраас ямар нэгэн байдлаар гэрээнээсээ буцах, цуцлах бол цуцлах нь өөрөө эргээд Монгол Улсын нэр хүндэд сөргөөр нөлөөлнө. Ийм учраас энэхүү гэрээг яг эцсийн шатад буюу соёрхон батлах үе шат дээрээ гишүүд маань хариуцлагатай байж, соёрхон баталж өгөөсэй гэж хүсэж байгаа юм нэг.

2 дахь нь болохлоор яг энэ Евразийн хэлэлцээртэй уялдуулаад яг энэ Тамхины хууль зэрэгцэж явж байгаатай холбоотой маш олон гишүүд энэ тамхины татвартай холбоотой Засгийн газрын зүгээс болоод Монгол Улс ер нь арга хэмжээ авах хэрэгтэй гэдгийг сануулж үг хэлж байгаа. Тэгэхээр энэ онцгой татварыг нэмэгдүүлэх боломжтой гэж Засгийн газар хэлж байгаа боловч яг тодорхой зохицуулалт орж ирээгүй байгаа нь ноцтой байна гэж үзсэн. Энэ Евразийн хэлэлцээрийг соёрхон батлахдаа дагасан тогтоол гаргаач, энэ тамхины яг энэ онцгой татварыг тусгайлж авч үзнэ, төдий хугацаанд оруулж ир гэдэг ч юм уу ийм тусгайлсан тогтоолоор үүрэг даалгавар өгөх хэрэгтэй байна гэдэг ийм хүсэлтийг гаргасан байгаа. Тэгэхээр яг энэ Байнгын хорооны хэлэлцэх асуудал дээр сая зарчмын зөрүүтэй санал гаргах ёстой байсан уу, сая хоцорчхов уу? Ямар байдлаар тогтоолын төсөл гарч байна вэ?

Түүнчлэн 3 жилийн хугацаатай байгуулж байгаа гэж байгаа боловч 3 жилийн дараа автоматаар сунгагдаад явах гэрээний заалттай байгаа юм. Тэгэхээр 3 жилийн дараа зайлшгүй үнэлгээ хийх даалгаврыг мөн өгөх.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Саяын Ариунзаяа гишүүний асуусан асуулттай холбогдуулаад би товчхон тайлбар хэлээдэхье. Таны саяын хэлсэн хөндсөн асуудлууд дээр, тамхитай холбоотой асуудлууд, хэлэлцээрийн биелэлттэй холбоотойгоор манай Байнгын хорооноос тогтоол гаргаж болно. Ингээд энэ асуудал маань Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийнхаа 44.5-д заасныхаа дагуу одоо горимын саналыг гаргах шаардлагатай байгаа. Байнгын хороо энэ хэлэлцээрийн төслийг дэмжсэнтэй холбогдуулаад манайх горимын санал гаргаад, энэ маань Байнгын хороон дээр дэмжигдвэл маргаашийн чуулган дээр ингээд тэр горимын саналаар санал хураалт явуулах ёстой байгаад байгаа. Горимын санал дэмжигдсэний дараагаар тогтоолын төслийг Байнгын хороонд оруулж ирж, батлуулах асуудал нээлттэй байгаа. Одоо ямар ч бай Бүлэг дээр болоод, гишүүдийн хэлсэн саналтай холбогдуулаад Байнгын хорооны зүгээс 2 зүйл, заалт бүхий хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тогтоолын төслийг ерөнхийдөө бэлдсэн байгаа. Энийг та бүхэнтэй зөвшилцөж, холбогдох саналуудыг авна гэдгийг хэлэх байна.

Энэ хэлэлцээр соёрхон батлах тухай хууль батлагдсантай холбогдуулаад хэлэлцээрийн биелэлт болон хяналтын чиглэлээр Засгийн газарт тодорхой 2 чиглэлээр үүрэг даалгавар өгсөн ийм Улсын Их Хурлын тогтоол байх болно. 1 дүгээр асуудал мэдээж энэ гаалийн тарифыг хэлэлцээрийн дагуу тэглэсэнтэй

холбогдуулаад тамхинд квот тогтоох, мөн тамхины хэрэглээнд хяналт тавих асуудлыг хэлэлцээр хуулийн дагуу хүчин төгөлдөр болох хугацаанд нэг мөр шийдвэрлэх саналыг Засгийн газар, Улсын Их Хуралд оруулж ирж танилцуулах гэдэг чиглэл өгөгдөнө.

2 дугаар асуудал маань хэлэлцээрийн биелэлтэд 3 жил тутам хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлгээний тайланг Улсын Их Хуралд танилцуулах гэсэн ийм үүрэг даалгавар өгөгдөхөөр байгаад байгаа. Тэгэхээр энэ асуудал нээлттэй гэдгийг хэлэх байна. Тэгээд горимын санал хэлэлцээрээ, хэлэлцээрийнхээ асуудлаар санал хураачхаад, араас нь горимын санал гаргаад, ингээд дэмжээд явна л гэсэн үг байх нь. Энхбаяр сайд нэмж хариулъя.

Ж.Энхбаяр: Тэгэхээр энэ Евразийн эдийн засгийн холбоотой хамтарсан хороо ажиллана. Хэлэлцээрээ нэг жилийн дотор бүхэлд нь хянаана. Жил бүр хэлэлцээрийн хэрэгжилтийг хянаад, асуудлаа шийдвэрлээд, энэ жагсаалт дээрээ дүгнэлт хийгээд явна. Энэ 3 жил хийгээд орхичих асуудал ердөө биш. Жил жилийн дүгнэлтээ оруулж, танилцуулаад, шаардлагатай бол Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороон дээрээ танилцуулаад л яваад байна гэсэн үг. Энэ бол нийт манай аж үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн салбар бол том зах зээлд том өрсөлдөөнд орно гэсэн үг.

Тэгэхээр энд бид олон жил бэлдсэн, одоо нэг өөрсдийгөө сорих цаг болсон. Тэгээд экспорт буюу шинэ зах зээлд гарч байж л эдийн засгаа тэлэх, өсгөх ийм зайлшгүй шаардлага байгаа. Тэрнээс тамхины асуудал бол яг энэ гэрээ соёрхон батлагдсан нөхцөлд асуудал үүснэ. Тэрнээс санаатайгаар тамхины асуудлыг орхиод оруулж ирж байгаа зүйл биш шүү. Тэгвэл буруу ойлгогдоно. Энэ яагаад гэвэл олон улсын гэрээ нь манай дотоодод үүссэн энэ тамхитай холбоотой асуудалтай хамаагүй байхгүй юу. Тэгэхээр бид олон улсын гэрээгээ хийчхээд, тэгээд дотооддоо зохицуулах эрх нь бидэнд нөөц бололцоо буюу онцгой албан татварын, НӨАТ-ын боломж нь байгаа үед тэрүүгээрээ зохицуулалтаа хийгээд, гаалийн татварыг нь онцгой албан татвараар нь бид солиод нэмээд л явчихна. Тэгэхээр энд ямар нэгэн эрсдэл гарахгүй.

Г.Тэмүүлэн: Ариунзаяа гишүүн нэмж тодруулъя.

А.Ариунзаяа: Тийм, цаг хугацааны хувьд тогтоолын төсөл нь өөрөө дагаж хэлэлцэгдээгүй байгаа учраас маргааш чуулганаар Евразийн хэлэлцээр дангаараа яригдаад, тогтоолын төсөл нь 1 долоо хоног хоцорч явах нь байна гэсэн ойлголтыг авлаа шүү дээ. Тэгэхээр нэг жоохон эрсдэлтэй юм шиг л санагдаж байна. Дараагийн долоо хоногийн ирц яах ч билээ. Ер нь тэгээд дараад нь гараа ч уу, үгүй ч үү. Зүгээр энэ Дэгийн тухай хуулийн 79.5-аар магадгүй тайлбар мэдэгдлийн төсөлтэй хамт баталж болно гэсэн байна. Болохгүй бол ийм яг энэ тамхины татвартай холбоотойгоор ямар ч байсан нэг зохицуулалтыг маргааш чуулган дээр гишүүдэд яг тодорхой хэлж өгөхгүй бол дахиад нөгөө эрсдэл үүсэх вий гэдэг ийм асуудал байгаад байгаа юм. Хамгийн гол нь энэ дипломат шуудангаар солилцсоноос хойш 60 хоногийн дараа хүчин төгөлдөр үйлчлэх байхгүй юу. Тэгэхээр яг энэ онцгой татварыг Улсын Их Хурлаар л эргээд хэлэлцэнэ. Тэгэхлээр хаврын чуулган 3 сард болох гээд байдаг, эргээд нөгөө цаг хугацааны хувьд асуудал үүсгэх вий гэсэн ийм болгоомжлол байна.

Г.Тэмүүлэн: Дэгийнхээ хуулиар ийм байгаа шүү Ариунзаяа гишүүнээ. Ариунзаяа гишүүн, ийм зүйл байгаад байгаа. Яг тухайн тэр түр хэлэлцээр соёрхон батлах тухай хууль батлагдсантай холбогдуулаад байгаа. Тэгэхээр эхлээд маргааш юу гэдэг юм чуулганаар энэ хэлэлцээр маань дэмжигдээд, ингээд манай Байнгын хорооноос гаргаж байгаа горимын санал маань Улсын Их Хурал дээр ороод, Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл гэж байгаа юм, тэнд бас дэмжигдээд ингээд бид эрхээ аваад ингээд явах нь гэсэн үг болчихож байгаа юм. Тэгэхээр энийг бол ямар ч бай нөгөө дэс дарааллынхаа хувьд Дэгийнхээ хуулиар ийм дараалалтай явах юм байна гэдгийг та ойлгоорой. Эрдэнэбүрэн гишүүн асуулт асууя.

Р.Эрдэнэбүрэн: Өдрийн мэнд хүргэе. Энэ хэлэлцээрийг дэмжиж байгаа. Олон жил манай талаас өөрсдөө санал тавьж, хүсэлт тавьж ингэж явж байгаад тэгээд Оюун-Эрдэнийн Засгийн газрын үед нэлээн их бодитой ажил хэрэг болоод ингээд явж байгаа ийм хэлэлцээр байгаа. Тэгэхдээ би 2, 3 асуулт асууя гэж бодож байна. Шинэ Эдийн засгийн сайд ирээд нэлээн үзэж анализ хийж харж байгаа байх. Энэ гэрээ хийснээр ялангуяа гуравдагч орнууд, Европын орнууд, Япон, Солонгостой хийж байгаа манай худалдаанд ямар нэгэн нөлөө үзүүлэх үү, ийм судалгаа байгаа юу?

2,4 хувиар хөрөнгө оруулалт нэмэгдэнэ гэсэн байна. Энэ хөрөнгө оруулалт хаанаас орж ирэх хөрөнгө оруулалт вэ 2 дугаар асуулт? Ямар чиглэлээр хөрөнгө оруулалт орж ирнэ гэж тооцоолж байгаа вэ? Энэ дээр хариулаад өгмөөр байна.

3 дугаарт ер нь би энэ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүддээ ялангуяа Цогтбаатар гишүүнд ялангуяа анхааралтай болгоомжтой байх ийм долоо хоног болж байна гэж ингэж хэлмээр байна. Энэ явж байгаа сонсголын талаар. Энэ долоо хоног бол энэ сонсгол ерөөсөө үндсэндээ тэр хориод оны үед соёлын Данзан тэргүүтэй хүмүүс шөнө дөлөөр гуравдагч орны Элчин сайд нарын хаалгыг тогшоод явж байсан тэр хүмүүсийн сүнс рүү шороо цацаж байгаа тийм үйлдэл болж байна. Ардчилсан хувьсгалын дараа гуравдагч хөршийн бодлого гэж гаргаж ирсэн тэрнээсээ няцаж байгаа Монгол ноёд тэрнээсээ няцаж байгаагаа илэрхийлж байгаа ийм өдрүүд болж байна. Тийм учраас ялангуяа Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүд бол их анхааралтай ажиглаж байх ёстой ийм цаг үе ирчхээд байна гэж бодож байна. Тэгээд Эдийн засгийн сайд энэ талаар ер нь ямар бодолтой байгаа вэ гээд ийм 3 асуулт асуух гэсэн юм?

Г.Тэмүүлэн: Энхбаяр сайд Эрдэнэбүрэн гишүүний асуултуудад хариулъя. 2 тодорхой асуулт асуулаа.

Ж.Энхбаяр: Бид боломж талаасаа илүү харж байгаа. Нэгэнт том зах зээл нээгдээд, Монгол Улсад бий болсон бүтээгдсэн бараа гаалийн болон тарифын хөнгөлөлт эдлээд ирэхээр энийг дагасан Монголд эцсийн бүтээгдэхүүн хийх, экспортлох, дээрээс нь реэкспорт хийх ийм сонирхол эрс нэмэгдэх нь тодорхой байгаа. Нөгөө талаар дотоодын хөрөнгө оруулалт буюу уламжлалт зах зээл дээр байсан хөрөнгө оруулалт том зах зээл гараад ирэхээр үйлдвэрлэлийн дотоодын хөрөнгө оруулалтууд нэлээн их болно. Гаднаас хөрөнгө оруулалт татах ийм таатай байдал үүснэ.

Бусад орнуудтай хийж байгаа худалдаанд айхтар нөлөөлөх зүйл байхгүй. Энэ уламжлалт энэ 367 бараа өөрөө Монгол Улсад импортолж байгаа л бараа. Гол нь тэд нарт тарифын, татварын хөнгөлөлт үзүүлснээр дотоодод нийлүүлэлт

нэмэгдэнэ, үнэ хямдарна, энэ нь инфляцад таатай нөлөөлнө гэсэн зүйл байгаа. Энэ нь нийлснээр бусад орны барааг мэдээж өрсөлдөөн нэмэгдэнэ гэсэн үг. Өрсөлдөөн нэмэгдэхийн хэмжээнд үнэ унана л гэсэн үг. Энэ дээр хэрэглэгчид ард түмэн хожно гэж үзэж байна. Тэгээд хамгийн гол нь бидний давуу тал 5 орны 200 сая хүний зах зээлд саадгүй нэвтрэх орчин худалдааны техникийн саад тотгорыг л арилгаж байгаа юм. Энэ бол манай өрсөлдөх чадварт их сайн нөлөөлнө. Барааны эргэлт нэмэгдэнэ. Энэ нь үнэхээр эдийн засагт эерэг үр дүнг үзүүлнэ гэдэгт итгэлтэй байгаа.

Оюу толгойн асуудлыг нийтээрээ нээлттэй хэлэлцүүлэг хийж байна. Энэ дээр ийм байр суурь одоо илэрхийлнэ, илэрхийлэх нь зохистой биш гэж үзэж байна.

Г.Тэмүүлэн: Эрдэнэбүрэн гишүүн нэмж тодруулъя.

Р.Эрдэнэбүрэн: Эдийн засгийн сайдын байр суурь сонсох их чухал байгаа юм. Ямар байр суурьтай байх нь гадагшаа өгөх мессеж чинь аймаар чухал байна. Ер нь бид ингээд нэг улсын нүүрс жоохон хэдэн жил гайгүй үнэтэй авч байгаад тэгээд тэрэнд нь баярлаад төсвөө данхайлгаад, зардлаа нэмчихсэн. Тэгэнгүүт одоо жоохон буцаад л 1, 2 сар ингээд нүүрсний үнэ чинь унангуут цалингаа тавьж чадахгүй байдал руу орж эхэлж байна шүү дээ. Тийм учраас энэ гуравдагч хөрш, гуравдагч хөршийн бодлого чинь ийм юмыг л урьдчилж харж явсан зүйл шүү дээ. Тэгээд илэрхийлэх шаардлагагүй гэж хэлэх боломжгүй санагдаад байгаа юм. Ялангуяа Эдийн засгийн сайд, олон улс харж байна.

Г.Тэмүүлэн: Сая ийм зүйлийг л Цогтбаатар дарга хэлсэн юм. Нөгөө Хууль зүйн байнгын хорооны хувьд Эрдэнэбүрэн гишүүний хэлээд байгаа зүйл маань энэ Улсын Их Хурлын хянан шалгах түр хороо байгуулагдаж байгаатай холбогдуулаад хянан шалгах энэ процесс болоод, дэгтэй холбоотой асуудлуудыг их тодорхой болгож өгөөч. Тэгээд Улсын Их Хурлын түвшинд нэг талдаа бид энэ хэт туйлшрахаас болгоомжлох, илүү ажил хэрэгч байдлаар энэ Хянан шалгах түр хорооны үйл ажиллагааг явуулах энэ дэгтэй холбоотой асуудлуудыг анхаарах шаардлага байна л гэдэг асуудлыг хэлж байгаа юм. Тэгэхээр мэдээж юу гэдэг юм энэ Оюу толгойн түр хорооны хяналт шалгалт явагдсаны дараагаар бид алдаа оноо, анх удаа тодорхой хэмжээнд ингээд шинэ дэгээр хэрэгжиж байгаа асуудлууд энэ дээр үнэлэлт дүгнэлт өгөөд, цаашдаа илүү энэ процессыг нь боловсронгуй болгох тал дээр эрх зүйн талаас нь анхаараарай гэсэн ийм саналыг хэлж байна шүү.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төсөлтэй холбогдуулаад үг хэлэх гишүүд байна уу? Алга байна. Санал хураалтыг явуулах байгаа. Сая гишүүдээс гаргасан саналын дагуу горимын санал гишүүд гаргасан байгаа. Эхлээд би юуны өмнө энэ горимынхоо саналаар санал хураачих нь зөв байх. Манайхан яг энэ Дэгийнхээ хууль процессыг сая нягталсан байх. Би бол уг нь эхлээд саналаа хураачхаад, дараа нь хураах ёстой юм болов уу гэсэн, эхэндээ хийх ёстой л гэсэн саналыг хэлж байна.

Горимын санал маань энэ хуулийн төсөл эцэслэн батлахтай холбогдуулаад хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолыг гаргах нь зүйтэй гэсэн ийм горимын санал байгаад байгаа юм. Энүүгээр эхлээд саналаа хураачихъя. Тэгээд. Эхлээд үндсэн асуудлаараа санал хураагаад, тэгээд дараа нь гишүүдийн гаргасан горимын саналаар санал хураагаад ингээд явна. Ямар ч бай мэдээж бол дагасан тогтоол дээр ямар нэг хугацаа заах зүйлийг эргээд бид дараагийн долоо хоногт ч юм уу ярихдаа бол яана. Тэгэхдээ мэдээж тэр чинь бусад

өөр улсын юугаар орж хэлэлцэгдээд, дэмжигдсэнийх нь дараагаас тодорхой хугацаагаар явна, тэгнэ гэсэн үг. Тийм. Эхлээд санал хураалтаа явуулъя.

Үндсэн санал хураалт. Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг батлахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалтыг явуулъя. Юуны өмнө гишүүд санал хураалтад бэлтгэхийг хүсье, санал хураалтад бэлтгэе. 12 гишүүн бэлэн байдалд байна. Ингээд хэлэлцээрийг Соёрхон батлах тухай хуулийн төслийг батлахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт. 70,6 хувиар дэмжигдсэн байна. Түр сууж байгаарай одоохон, одоо дагасан тогтоолын төсөл дээр яачихъя. Тэгээд мэдээж томьёолол дээр нь эргээд Засгийн газартайгаа хамтраад хэдүүлээ хугацаа, томьёолол юун дээр нь суугаад хэзээ оруулах барихаа дараа нь тогтож болно. Мэдээж зүгээр Их Хурлаасаа, тэгж байгаа. Үгүй ээ, гол үндсэн асуудал маань ингэж байгаа.

Би 2 дахь асуудал дээр нь горимын санал гишүүд гаргая гэсэн санал гаргасан байгаа. Энэ асуудал маань өөрөө юу юм бэ гэхээр гишүүдээс гаргасан болгоомжтой холбоотойгоор тамхи агуулсан янжуурын гаалийн тарифыг хэлэлцээрийн дагуу тэглэх асуудал үүснэ. Хэрэв тэглэсэн тохиолдолд тодорхой хэмжээнд тамхи дээр квот тогтоох, тамхины хэрэглээн дээр хяналт тавих асуудлыг хэлэлцээр хуулийн хүчин төгөлдөр болох хугацаанд нэг мөр шийдвэрлэх саналтай байна гэсэн саналыг гаргаж байгаа. Тэгж байгаа юм.

2 дугаар асуудал нь энэ хэлэлцээр маань 3 жилийн хугацаагаар байгуулагдаж байгаа түр хэлэлцээр. Цаашид хэлэлцээрийн биелэлтэд нь 4 жил тутам бид нэг хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг нь Улсын Их Хуралд танилцуулж байх ёстой гэсэн зүйл байгаа. Ирц хэд байна вэ? Тэгэхээр Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг үндэслээд, хуулийн төсөл эцэслэн батлахтай холбогдуулан хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолыг гаргах нь зүйтэй гэсэн томьёоллоор, саналаар, горимын саналаар санал хураалтыг явъя. Гишүүд анхааралтай байгаарай, дэмжье гэдгээр санал хураана. Санал хураалт. 52,9 хувиар дэмжигдлээ. Гишүүдэд баярлалаа, ажлын хэсгийнхэнд баярлалаа.

15.35 цаг

Хоёр.Эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, эрчим хүчний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлого, арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, хариуцлагын талаарх Эрчим хүчний сайдын мэдээллийг сонсох

Ингээд 2 дахь асуудалдаа орцгооё. 2 дахь асуудал маань эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, эрчим хүчний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлого, арга хэмжээ, төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн хариуцлагын талаарх Эрчим хүчний сайдын мэдээллийг сонсохоор байгаа.

Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулаадахъя. Эрчим хүчний сайд Чойжилсүрэн, тус яамны газрын дарга нар, Эрчим хүчний яамны ТНБД Ерэн-Өлзий, Эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлогын зохицуулах газрын дарга Батзориг, Эрчим хүчний

яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Хуягцогт, Эрчим хүчний яамны Стратеги, төлөвлөлтийн хэлтсийн дарга Энхтүвшин, Эрчим хүчний зохицуулах хорооны Үнэ тарифын газрын дарга Эрдэнэбулган гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр оролцож байгаа юм байна. Ингээд мэдээллийг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн гишүүн хийнэ. Таныг микрофонд урьж байна. Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Эрхэм Байнгын хорооны дарга, гишүүд ээ,

Эрчим хүчний салбар Монгол Улсын Үндэсний аюулгүй, бие даасан байдлыг хангах стратегийн ач холбогдол бүхий салбарын нэг билээ. Улсын хэмжээнд 2024 онд эрчим хүчний хэрэглээ 11,6 тэрбум квт цаг болж, жилд 5,9 хувийн өсөлттэй байна. Монгол Улсын дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ 2024 онд 8,7 тэрбум квт цаг болж өмнөх оноос 2,7 хувиар өссөн ба нийт хэрэглээний 75,4 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангасан. Хэрэглээний 24,6 хувь буюу 2,8 тэрбум квт цаг цахилгааныг импортоор авсан нь өмнөх онтой харьцуулахад 17 хувиар өссөн байна. Эрчим хүчний оргил ачааллын халаалтын хэрэгцээнээс үүдэн өвлийн улиралд тохиодог өнгөрсөн оны хувьд цахилгаан эрчим хүчний хамгийн их ачаалал 1655мвт-д хүрсэн ба оргил ачааллын өсөлт сүүлийн жилүүдэд дунджаар 10 орчим хувь байна. Өвлийн их ачааллын саруудад суурь горимд ажиллах дулааны цахилгаан станцууд суурилагдсан хүчин чадлаараа нөөц тоноглолгүй ажиллаж байгаа нь эрчим хүчний хангамжийн тасралтгүй, найдвартай байдлыг хангахад эрсдэлтэй нөхцөл байдал бий болж байсан.

Сүүлийн 2 жилийн хугацаанд Улаанбаатар хотод Бөөрөлжүүтийн 300 мвт-ын станц, Сонгинын 80 мвт, Багануур дүүрэгт 50 мвт-ын батарей хуримтлуурын станцууд, Дорноговь аймгийн Эрдэнэ сумд 30 мвт-ын нарны цахилгаан станц, Хөвсгөл аймгийн төвд 10 мвт-ын нарны цахилгаан станц, Дорнод бүсийн эрчим хүчний системд Чойбалсангийн 5 мвт-ын шинэ дулааны станц, саяхан Тосонцэнгэлийн 22 мвт-ын цахилгаан станцууд ашиглалтад орсон хэдий ч цахилгаан эрчим хүчний хэрэглээний өсөлт өндөр байгаа тул нөөц чадал бүрдэхгүй байна.

Эрчим хүчний яамны зүгээс цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх уламжлалт эх үүсвэрийн төслүүдийг хувийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлж ажиллаж байна. Ирэх онд Сэлэнгэ аймгийн төвд 70 мвт-ын дулаан, цахилгаан хослон үйлдвэрлэх станц ашиглалтад орох бөгөөд 2027-гоос 2028 онд Баян сумд 660 мвт-ын цахилгаан станц, 28-аас 29 онд Бөөрөлжүүтийн цахилгаан станцын 2 дугаар ээлж 300 мвт-ын станц ашиглалтад орсноор өвлийн оргил ачааллын саруудад нөөц чадалтай болох боломж бүрдэнэ.

Улаанбаатар хотын дулаан хангамжийн тулгамдаж буй асуудлын тухайд. Улаанбаатар хот дулаан хангамжийн хувьд хүндрэлтэй нөхцөл байдалд байна. Улаанбаатар хотод агаарын температур -39 хэмээс доош хүйтэрсэн тохиолдолд дулаан хангамжийн систем чадлын дутагдалд орж, дулаан хангамжийн системийн эх үүсвэрээс алслагдсан цэгүүдэд хүндрэл нь өсөх нөхцөл өндөр хэвээр байна. Улаанбаатар хотод жилд дунджаар 190 гига килокалори цагийн хэрэглээ бүхий 280 гаруй барилга байгуулж төвлөрсөн дулаан хангамжийн системд шинээр холбогдож байна. Нийслэлийн дулааны хэрэглээ жилд 7-гоос 8 хувиар өсөн нэмэгдэж, энэ хэмжээгээр хэрэглээний өсөлт тогтвортой гарвал 2025 оны түвшинд холбогдсон хэрэглэгчдийн ачаалал 3874 гига килокалори цаг болно.

Нийслэлийн төвлөрсөн дулаан хангамжийн системд 2024 онд Амгалан дулааны станцыг 116 мвт-аар, 116 мвт-ын өргөтгөлийг ашиглалтад оруулснаар хүчин чадал бага хэмжээгээр нэмэгдсэн боловч хэрэглээний өсөлтийг бүрэн хангаж чадахгүй байдалтай байна. Дулааны 3 дугаар цахилгаан станцын дэд бүтцийг ашиглан шинээр 300 мвт-ын цахилгаан, 395 мвт-ын дулаан үйлдвэрлэх шинэ станцыг ОХУ-тай хамтран хэрэгжүүлэхээр, дулааны 2 дугаар цахилгаан станцын дэд бүтцийг ашиглан 300 мвт-ын цахилгаан, 395 мвт-ын дулаан үйлдвэрлэх шинэ станцыг нийслэлийн зүгээс төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр холбогдох гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан бол дулааны 4 дүгээр цахилгаан станцыг 500 тонн цаг буюу 210 мвт дулаан үйлдвэрлэх хүчин чадалтай зуухаар өргөтгөх төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай байна.

2.Цаашид эрчим хүчний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлогын талаар. Эрчим хүчний зөвлөлөөс улс орнуудын эрчим хүчний нөхцөл байдлыг харуулдаг гуравласан үзүүлэлтийн нэг нь эрчим хүчний аюулгүй байдлын индекс ба уг индекс нь 3 үндсэн хүчин зүйлээс хамаардаг. 1 импортын хамаарал, 2 эх үүсвэрийн төрөлжилт, 3 байгалийн хий болон нефтийн бүтээгдэхүүнээр өөрийгөө хангахад шаардагдах түлш хадгалах агуулах зэрэг болно. Эдгээрээс Эрчим хүчний яамны эрхлэх асуудлын хүрээнд эхний 2 асуудал хамаарч байна. Эрчим хүчний аюулгүй байдлыг дээшлүүлэхэд шаардлагатай импортын эрчим хүчний хамаарлыг бууруулах хүрээнд Монгол Улсыг 2026-аас 2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн зорилтот түвшинд 2024 оны жилийн эцсийн байдлаар 24,6 хувийг эзэлж байсан цахилгаан эрчим хүчний импортын хэмжээг 2030 он гэхэд дотоодоос бүрэн хангах боломжийг бүрдүүлэхээр тусгасан ба уг зорилтод хүрэхэд нийт 2040 мвт-ын 9 нүүрсээр ажилладаг дулааны цахилгаан станцын төсөлд 11,8 их наядын хөрөнгө оруулалтыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэхээр тусгасан.

Мөн санхүүжилт шийдвэрлэх шаардлагатай 635 мвт-ын 3 цахилгаан станцын төсөл байна. Үүний зэрэгцээ 2019 онд Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд орсон шинэ зохицуулалтын дагуу алслагдсан бүс нутгийн 6 байршилд батарей хуримтлуур бүхий 115 мвт-ын хүчин чадалтай нарны цахилгаан станцын төслүүд болон Дундговь аймагт 100 мвт-ын салхин цахилгаан станцын төслийг хувийн хөрөнгө оруулалтаар өрсөлдөөнт сонгон шалгаруулалтаар хэрэгжүүлнэ. Төслийн сонгон шалгаруулалтыг 2026 оны 5 дугаар сард зарлахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Эх үүсвэрийн төрөлжилтийг нэмэгдүүлэх замаар эрчим хүчний аюулгүй байдлыг сайжруулах хүрээнд эрчим хүчний салбарын эх үүсвэрийг төрөлжүүлж, системийн горим тохируулгын үүрэг гүйцэтгэх том чадлын батарей хуримтлуур, усан цахилгаан станц болон усан цэнэгт цахилгаан станцын төслүүдийг хэрэгжүүлэх шаардлага бас байна. Өнгөрсөн хугацаанд Сонгинын 80 мвт, Багануурын 50 мвт-ын батарей хуримтлуурын төслүүд ашиглалтад орсон бол Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд гадаадын хөрөнгө урвалтаар 400 мвт-ын гаралтын чадалтай том чадлын өөрийгөө цэнэглэх батальон хуримтлуур, Эрдэнэбүрэний усан цахилгаан станц, Байдрагийн усан цахилгаан станц болон 2 байршилд нийт 400 мвт-ын чадалтай усан цэнэгт цахилгаан станц барихаар тусгасан болно.

Эдгээр горим тохируулга нь үүрэг гүйцэтгэх эх үүсвэрүүдийг үе шаттайгаар барьж байгуулснаар нийт суурилагдсан хүчин чадалд эзлэх сэргээгдэх эрчим

хүчний хэмжээ Монгол Улсыг 2026-аас 2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн үндсэн чиглэлийн зорилтот түвшинд тусгасны дагуу 24 оны түвшинд 20,2 хувь байсан бол 2030 онд 30 хувьд хүрэх техникийн боломж бүрдэж, эрчим хүчний системийн эх үүсвэрийн төрөлжилт сайжрах боломжтой юм.

3 дугаар сэдэв нь гадаад зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн талаар. Эрчим хүчний яамны зүгээс хувийн хэвшил, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэхэд санхүүгийн хувьд хүндрэлтэй, стратегийн ач холбогдол бүхий томоохон төслүүд болох усан цахилгаан станц, дулааны цахилгаан станц, цахилгаан дамжуулах агаарын шугамын төслүүдийг хөгжлийн түнш орнууд болон олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын урт хугацаатай, нэн хөнгөлөлттэй Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлж байна. 2025 оны байдлаар 681 сая ам.долларын өртөг бүхий 8 төсөл, арга хэмжээг гадаад зээлээр хэрэгжүүлж байна. Та бүхэнд Байнгын хорооноос ирүүлсэн асуулгын хариуг дэлгэрэнгүй байдлаар хүргүүлсэн болно. Анхаарал тавьсанд баярлалаа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар 15 цаг 37 минутаас хуралдааныг даргалав.

Д.Цогтбаатар: Чойжилсүрэн сайдад баярлалаа. Ингээд сая танилцуулсан асуудалтай холбогдуулан, энэ мэдээлэлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү? Хосбаяр гишүүнээр тасаллаа. Хосбаяр гишүүний микрофоныг өгье.

Г.Хосбаяр: Би Чойжилсүрэн сайдаас нөгөө л асуудаг 10 аймгийн дулааны станц, энд ч яах вэ мэдээллийг нь нэлээн дэлгэрэнгүй өгсөн байх шиг байна. Мэдээллүүдийг ч бас байнга л авч байгаа. Тэгээд энэ маань ер нь яг яах вэ? Ер нь энэ гадаад, энэнтэй холбоотойгоор энэнээс ч гадна ер нь өөр энэ гадаадын зээл, тусламжаар танай салбарт хэрэгжиж байгаа энэ төсөл, хөтөлбөрийг, хөтөлбөрийн үр ашиг, үр дүн ер нь ямар байна вэ? Ер нь бид энэ гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын зээл, тусламж дээрээ нэг анхаарахгүй бол маш их цаг хугацаа ордог.

Энэ 10 аймгийн дулааны станцын төсөл чинь гэхэд аль 2013, 2014 оны үед л бараг тэр Солонгосын эмэгтэй Ерөнхийлөгчийн үед л яригдаж байсан, анх хэлэлцээр нь хийгдсэн асуудал. Тэгээд одоогоороо ингээд хэрэгжиж дуусаагүй байдаг. Дахиад хэзээ дуусах нь мэдэгдэхгүй ийм байна л даа. Тэгэхээр зэрэг энэ 10 аймгийн станцыг ер нь яг яах вэ? Тэр хөдөө орон нутагт сая би өчигдөр Өвөрхангай аймагт ажиллаж байгаад ирлээ. Тэр аймгийн төвийн утаа чинь улам л их болоод байна жил ирэх тусам, агаарын чанарыг хэмждэг болсон байна. Агаарын чанарын үзүүлэлт нь бас аймгийн төв дээр жил ирэх тутам л муудаад байдаг. Тэгэхээр энэ дээр ер нь энэ төслийг ер нь яг яах вэ?

2 дугаарт нь та дэд бүтцийн салбарт ажиллаж байсан олон жилийн туршлагатай хүн. Энэ Монгол Улс маань Эрчим хүчний яам, Зам, тээврийн яам, Барилга, хот байгуулалтын яам гээд баахан яам салгачихсан чинь энэ нийтдээ энэ дэд бүтцийн салбар гэж явахгүй бол ер нь уялдаа холбоо чинь алдагдаад байгаа юм биш үү? Одоо тэгээд бүүр ингээд нарийн гүйцэтгэгч компанитай нь хүртэл тэр станцын барилга барьж байгаа гүйцэтгэгч компанитай хүртэл уулзахаар одоо бараг л барилгын асуудал Барилгын яам барилгатай холбоотой асуудлаас болоод л энэ

төсөл ер нь бүтэлгүйтсэн юм байна лээ шүү дээ. Тэгэхтэйгээ зэрэг мэдээж энэ төслийн ач холбогдол энэ тэр компани ч гэсэн тэр ажлыг хийчихье л гэж явсан байлгүй дээ. Тэгээд одоо амжилтгүй болчихсон.

Тэгэхээр ер нь цаашдаа энэ улс маань Дэд бүтцийн яам ч гэдэг юм уу, хуучин байсан даа тэрэн шиг ингээд энэ дотроо бүх юмаа ингээд зангидаад авч явахгүй бол нэг нэг яам эрчим хүчний барилга, байгууламж барилгатай холбоотой асуудал, замтай холбоотой асуудал гээд олон асуудал байна. Тэгэхээр энэ дээр та ер нь ямар байр суурьтай байдаг юм бэ? Энэ дэд бүтцийн хөгжил, энэ дэд бүтцийн асуудал дээр. Тэгээд 10 аймгийн дулааны станц дээр нэг маш тодорхой гарц гаргалгаатай тийм нэг хариу хэлбэл сайн байна.

Д.Цогтбаатар: Чойжилсүрэн сайдын микрофоныг өгье.

Б.Чойжилсүрэн: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Энэ манай би 2022 оны 8 сарын 30-нд түрүүчийн Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд Эрчим хүчний сайдаар томилогдож ажилласан. Намайг очиход манай салбарын төслүүд нэлээн тийм гацалттай зогсчихсон ийм хүндрэлтэй байсан. Дорнодын 50 мвт-ын цахилгаан станцыг ашиглалтад оруулсан. Сонгино дээр 80 мвт-ын батарей хуримтлуурын станцыг ашиглалтад оруулсан. Нийслэлээс санаачилсан энэ Багануур дээр 50 мвт-ын батарей хуримтлуурын станц ашиглалтад орсон. Эрдэнэбүрэний усан цахилгаан станц гацаад зогсчихсон байсныг ямар ч байсан гацаанаас гаргаад, ажил хэвийн үргэлжилж байна, 2029 он гэхэд ашиглалтад орчих болов уу гэсэн ийм тооцоололтой явж байгаа.

Ганц энэ асуудлыг шийдэж чадаагүй үлдсэн нэг ийм төсөл байна. Энэ 10 аймгийн төсөл гээд. 2021 онд тендер зарласан юм байна лээ, 3 удаа зарлаад, 3 дахь юу, эхний 2 дээр нь компани орж ирээгүй, 3 дахь дээр нь жоохон техникийн шаардлагыг нь бууруулаад зарласан чинь нэг компани орж ирсэн юм байна лээ, миний өмнөх сайдын үед. Тэгээд 2021 онд тендер юу гэрээгээ байгуулаад, 22 оны, 21 оны төгсгөл, 22 онд ковид гэх мэт шалтгаанаар ажил нь саармагжиж явсан. Би 22 оны 8 сарын 30-нд ирээд, энэ ажлаа хурдлуул гэдэг ийм шаардлага тавьсан. 2023 оны 3 сарын 31 гэхэд ажлын нарийвчилсан зургаа манай Эрчим хүчний хөгжлийн төвд заавал батлуулсан бай гэдэг эхний шаардлага тавьсан. Янз бүрийн шалтгаан хэлж явсаар байгаад 2023 ондоо бүтэн зураг нь болохгүй байна гэдэг ийм шалтгаан яриад яваад байсан.

Солонгосын Элчин сайдтай уулзсан, санхүүжүүлж байгаа Korea эксим банкттай уулзсан, энэ компаниа шахаач гээд. Ингээд тэдгээр Солонгосын улс төрчдийн нөлөөгөөр ямар ч байсан 2023 оны төгсгөлөөр энэ компани зургаа тал дутуу юм авчирч өгсөн. 2026 оны 5 сарын 31-ний өдөр ашиглалтад оруулна гэдэг ийм төлөвлөгөөтэй явж байснаа энэ өнгөрсөн жил дампуурлаа зарлаад энэ төслийг хэрэгжүүлэгч Солонгосын компанид Солонгосын хуулиар нөгөө Дампуурлын хуультай юм байна. Манай Монголын банкны дампуурлын хууль гээд. Энэ хуулийн процесст байгаа, цаг хугацаа алдагдсан тал бий. Сүүлдээ Korea эксим банкттай бид энэ компанийг Бьюксан Инженеринг гэдэг компаниар дуусгуулах нь утгагүй боллоо гэдэг дээр санал нэгдсэн. Korea эксим банкнаас ч үнэлгээний баг ирсэн байгаа, манай Эрчим хүчний яам, Эрчим хүчний хөгжлийн төвөөс бид тусдаа нэг баг бий болгоод, одоо энэ Бьюксан Инженеринг компанийн хэрэгжүүлж байсан төслийг дуусгахад хэдэн төгрөгийн төсөв, яг төсөв хэрэгтэй гэдгийг ойрын өдрүүдэд бэлэн болгоно. 2 талаасаа яриад, сая 9 сард ирээд Солонгосын баг ирээд явсан.

Энэ дуусгах төсөв хэд байхаас шалтгаалаад энэ зээлийн хэлэлцээрийг цааш нь үргэлжлүүлэх юм уу, эс үргэлжлүүлэх үү гэдгээ бид энэ ондоо багтааж шийдэх бодолтой ингээд ажиллаж байна. Энэ тал дээр энэ Солонгос Улсаас Монголд суугаа Элчин сайд их ач холбогдол өгч байгаа. Монгол Улсаас Солонгос Улсад суугаа Элчин сайд ч мөн ялгаагүй ийм ажилтай явж байгаа юм. Тэгэхээр бид энэ 2026-аас 2027 оны бүтээн байгуулалтын энэ ажил эхлэхээс өмнө энэ асуудлыг нэг талд нь гаргаж шийдэх шаардлага үүссэн ийм байдалтай байна. Энэ компанитай үнэхээр олон удаа маргасан. Сүүлдээ Авлигатай тэмцэх газарт шилжүүлсэн, энэ учрыг нь олох гэж. Нэг ийм төвөгтэй төсөлтэй учирчихлаа. Та бүхнийг мэдээж сонгогчид чинь манай аймгийн дулааны төсөл хэзээ ашиглалтад орох вэ гэдэг байнга энэ асуултаар шахаж л байгаа байх. Ийм байдалтай явж байгаа.

Д.Цогтбаатар: Гүйцээгээд хариулуулах уу? Чойжилсүрэн сайдын микрофоныг өгье, гүйцээгээд хариулъя.

Б.Чойжилсүрэн: Бусад төслүүдийн тухайд би сая танд хэллээ. Манай эрчим хүчний салбарт хэрэгжүүлж байгаа гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төслүүд бусад нь ямар нэгэн саатал байхгүй байгаа, байгуулсан гэрээнийхээ хүрээнд ажил явж байгаа ийм байна.

Энэ дэд бүтцийн салбарын талаар хоорондын уялдаа холбооны тухай та ярилаа. Энэ Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай хуулийг Ерөнхий сайдын бүрэн эрх учраас Ерөнхий сайд өөрөө энийг Их Хурлаар ямар бүтэцтэй, ямар зүйл дээр ач холбогдол өгөх вэ гэдэг ийм бодлогоо тодорхой болгоод, Их Хурлаар батлуулж авдаг учраас би Их Хурал юу, Ерөнхий сайдын бүрэн эрхэд халдаж ямар нэгэн байр суурь яримааргүй байна. Би Засгийн газрын гишүүн хийж байгаа хүний хувьд уучлаарай та.

Д.Цогтбаатар: Хосбаяр гишүүний микрофоныг өгье, тодруулъя.

Г.Хосбаяр: Та тэр 10 аймгийн дулааны станц жишээлбэл Өвөрхангай аймаг дээр баригдаж байгаа станцын тухайд 10 гаруй сая долларын төсөвт өртөгтэй, Монгол төгрөгөөр тооцвол 50 гаруй тэрбум төгрөгийн л төсөвт өртөгтэй ийм төсөл байгаа юм л даа. Тэгээд нэг их овойж оцойсон ч юм байхгүй нэг аймгийнх нь. Тэгээд одоо 45 хувийн гүйцэтгэлтэй гэхээр дахиад 20 гаруй тэрбум төгрөг байвал дуусчихмаар санагдаад байгаа юм. Тэгэхээр ер нь энэ гэрээгээ бүр цуцлаад, тэртээ тэргүй энэ Солонгосын Эксим банкных чинь зээл шүү дээ Монголчууд дахиад л хойч үе төлнө, ирээдүйд хүүтэй төлнө, одоо бүр хүүг нь төлөөд явж байгаа. Тэгэхтэйгээ зэрэг энийг төсвөөрөө дуусгачхаж болдоггүй юм уу? Энэ дээрээ ер нь нэг зоригтой шийдэл авбал, арга хэмжээ авч болдоггүй юм уу гэдэг нэг асуулт байна?

2 дугаарт энэ хангайн бүсийн 3 аймагт 10 мвт-ын сэргээгдэх эрчим хүчний төсөл яригдаж байгаа. Тэгээд ийм юм хийх шаардлага ер нь байгаа юу, энийг ер нь дэмжих үү? Энэ хийчихвэл уг нь зүгээр байдаг. Тэгээд энэ дээр нэг таны байр суурийг сонсьё.

Д.Цогтбаатар: Чойжилсүрэн сайдын микрофоныг өгье.

Б.Чойжилсүрэн: Хосбаяр гишүүн яг ийм таны яриад байгаа хувилбар байна шүү дээ, хэрвээ энэ Солонгосын талын дүгнэлтээр хэт өндөр үнэтэй дуусах төсөв

гарч ирвэл энэ гэрээг цуцалж, аль, аль талдаа хариуцлагын тухай ярих асуудлыг хөндөнө. Боломжийн одоо байгаа тэр төсвийнхөө хүрээнд нэг их хэтрүүлэхгүйгээр ойролцоо дүнгээр байвал энэ Солонгосын Korea Эксим банкны санхүүжилтээр нь дуусгачихъя гэдэг ийм л байр суурьтай байгаа юм. Энийг ямар ч байсан 2026 оны 3 сард заавал эхлүүлнэ, тэгээд чадвал 2026-аас 27 оны халаалтын улирлаас эхлэхээс өмнө уул нь дуусгачихмаар л төсөл. Тийм их нарийн, төвөгтэй юм байхгүй, хэдэн уурын зуух юм шүү дээ. Уурын зуух л байгаа. Сэргээгдэхийн тухайд бид энэ төвийн бүсэд бол.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Ахиад юу авах уу? Чойжилсүрэн сайдад микрофон өгье.

Б.Чойжилсүрэн: Ийм байгаа төвийн бүсдээ бид нөгөө сэргээгдэх эрчим хүч холбуулах орон зай тогтворжилтын хувьд их төвөгтэй байна. Дундговь аймгийн Сайнцагаан сум дээр 100 мвт-ын салхины цахилгаан станцыг Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулиар уралдаант сонгон шалгаруулалтаар зарлаж үзье гэдэг нэг ийм зүйл яригдаж байгаа. Зүүн бүсдээ 65 мвт-ыг байх ойролцоо бид чинь, 55 мвт-ын, баруун бүсдээ 65 байна уу, яг 60 мвт-ын хүчин чадалтай, холбогдох батарейтай тийм төслийг баруун бүс, зүүн бүс 2 дээр зарлахаар 2026 оны 2 дугаар улиралд зарлахаар ийм бэлтгэл ажил хийгээд явж байгаа ийм байдалтай л байгаа юм. Тантай санал нэг, бусад юунууд дээр нь ийм тогтворгүй эх үүсвэр чинь их төвөгтэй байна.

Д.Цогтбаатар: Жангабыл гишүүний микрофоныг өгье.

Х.Жангабыл: Та бүхэнд өдрийн мэндийг хүргэе. Чойжилсүрэн сайдад их баярлалаа. Надад нэг асуулт байна. Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэр дээр 20 мвт-ын нарны цахилгаан станцын сонгон шалгаруулалт хэзээ явагдах юм бэ? 20 мвт-ын нарны цахилгаан станц баригдахаар тийм шийдвэр гарсан. Ер нь нарны энэ станцын үнэ тариф ер нь юу болоод байна вэ? Дэлхийд нэлээд буучихсан үнэ тариф нь тийм байдалтай байгаа шүү дээ. Манай орны хувьд сэргээгдэх эрчим хүч, тэр дотроо нарны цахилгаан станцын үнэ тарифын талаар та мэдээлэл өгөөч?

Д.Цогтбаатар: Чойжилсүрэн гишүүний микрофоныг өгье.

Б.Чойжилсүрэн: Жангабыл гишүүний асуултад хариулъя. Танай аймгийн тухайд энэ баруун аймаг дээр байгаа 60 мвт-ын хүчин чадалтай 4, 5 станцыг бид байрлалыг нь оновчлоод байгаа юм. Аль дэд станц дээр байвал бид энэ цахилгаан эрчим хүчний найдваржилтад хэрэгтэй вэ гэдгээ. Яг эцэслэн шийдээгүй байгаа шүү, 2026 оны 2 дугаар улиралдаа багтаж зарлахаар ийм тооцоололтой байна гэсэн үг. Тэр саяын миний энэ Хосбаяр гишүүний асуултад хариулахад дурдсан баруун бүсэд зарлагдах 60 мвт-ын 20 мвт-ыг нь танай Баян-Өлгий аймагт зарлая гэсэн ийм байр суурьтай байгаа. Батарейных нь хэмжээг надад хэлээдэх, 15 мвт-ын гаргалтын юутай 60 мвт-ын нийт багтаамж нь, цагийг нөхөх багтаамжтай ийм төслийг хэрэгжүүлэхээр Баян-Өлгий аймагт төлөвлөж байгаа.

Манай улсын тухайд 2019 онд Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулаад, шууд тусгай зөвшөөрөл өгөхгүй, тухайн байрлал дээр сонгон шалгаруулалт зарладаг ийм хуулийн зохицуулалттай болсон. Манайтай ижил ойрхон түвшинд байгаа Казахстан, Узбекистан улсуудын юугаар бол Дэлхийн банк болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк гээд эдгээр байгууллагуудтай хамтран сонгон шалгаруулалт зарлаж байна гэдэг ийм мэдээллийг уулзаад

авахлаар 2,7 цент гэсэн ийм нөхцөл байна. Зарим нь байршлаасаа шалтгаалаад 3 цент гаруйтай ч юм ийм мэдээллүүд ирж байгаа. Яг Монголын нутаг дэвсгэр дээр, тэгээд бүс бүсээрээ ялгаатай энэ чинь. Тухайн байрлал дээр ямар үнэтэй байх вэ гэдгийг яг сонгон шалгаруулалт зарлаж байж зах зээлийн бодит үнэ тогтох. Би бол танд хэллээ энэ баримжаа үнэ. Манайтай ижил уртраг, өргөрөг дээр байгаа улс орнууд дээр ийм баримжаа үнийн санал өгч байгаа юм байна лээ.

Д.Цогтбаатар: Жангабыл гишүүн хариулт хангалттай юу? Ингээд тэгвэл гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Мэдээлэлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү? Үг хэлэх гишүүн алга. Байнгын хорооны хуралдаанаар Эрчим хүчний сайдын мэдээллийг сонсож дууслаа.

15.59 цаг

Түрүүний хэлэлцсэн асуудлаас нэг зүйл орхигдсоныг би гүйцээж Байнгын хороонд танилцуулах ёстой гэж бодож байна. Энэ нөгөө Евразийн чөлөөт худалдааны хэлэлцээрийн асуудлыг танилцуулах хүнийг чуулганд Байнгын хороо өөрөө томилох ёстой. Тэгэхлээр Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир нэгдсэн хуралдаанд илтгэнэ.

Хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Хуралдаанд оролцсон гишүүддээ талархал илэрхийлье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА